

ЭЦЭГ ЭХЭЭ ҮЗЭХ МОНГОЛ, ЯПОН ХҮНИЙ СЭТГЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГ

Д. Дэлгэрсүрэн

Бурхан багшийн гэгээн сургаалд “Өвөг дээдэс, эцэг эхээ ачлан хүндлэх уламжлал гэгч өнө эрт, өдгөө, ирээдүйд ч байх эрхэм дээд ариун ёс мөн” гэжээ.

Энэхүү эрхэм дээд ариун ёс нь хүнийг хүн болгон төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд бэлтгэхэд маш чухал зүйл бөгөөд цаашлаад эцэг өвгөдөөс уламжилж ирсэн эцэг эхийгээ ачлан хүндлэх, үр хүүхдээ сайн хүн болгон өсгөн хүмүүжүүлэх зан заншлаа хадгалан хамгаалж, хөгжүүлснээр тухайн үндэстний хэл, соёл, ёс заншил оршин тогтнох дархлааг бий болгоно.

Манай ард түмэн эртнээс нааш эцэг эхдээ маш хүндэтгэлтэй хандаж ирсэн бөгөөд энэ зан заншил нь ардын аман зохиол, бэлэг дэмбэрэлийн үг, зүйр үг, оньсого таавар, ертөнцийн гурав, шүлэг, яруу найраг, дуунд туссан байдаг.

Аливаа үндэстний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний онцлог нь зүйр үгэнд илэрч байдаг. Зүйр цэцэн үгийг ард түмний оюун билгийн нэвтэрхий толь гэж хэлж болно. Зүйр үг нь хүмүүсийн харилцааны дүнд бий болсон зүйл болохын хувьд түүнд монгол хүн эцгээ, эхээ мөн эцэг-эхээ үзэх үзэл хэрхэн туссаныг, монгол хэлний эцэг эхийн тухайт 153 зүйр үг, япон хэлний эцэг эхийн тухайт 126 зүйр үгийг ашиглан ажиглахыг зорилоо.

Монгол, япон эцэг хүний эхээ үзэх үнэлэмжид төсөөтэй талууд байхаас гадна бас хоёр өөр соёл иргэншил, өв уламжлалтай ард түмний хэлний баримт болохынхувьд бас ялгаатай талууд ажиглагдсан. Монгол, япон хэлэнд утга агүүлга, үг хэллэг, илэрхийлж буй зүйрлэл, юм үзэгдлээрээ төсөөтэй зүйр үгс хэд хэд ажиглагдлаа. Эдгээр зүйр цэцэн үгийг харьцуулбал:

Монгол: “Үрийн сайныг авъя гэвэл эхийг нь шинж”

Япон: “Охины нь шинжихээр эхийг нь шинж”

Монгол: “Эх муутын хүүхэн битгий ав, үүд муутын хоймор битгийсуу”

Япон: “Эцэг эхийг нь харж хүүхдийг нь ав” гэсэн нь эцэг эх, өвөг дээдсээр нь удам судрыг нь шинжих, эхээр нь үр хүүхдийг нь шинждэг үзэл ижил байна. Мөн “Эх хүн бүх юмны үүтгэл болохын хувьд бас бүх юмны үлгэр болдог”²⁵ гэсэн үзэл бас харагдаж байна.

Мөн хойт эх, салхи хоёрийг адилтгасан байна.

Монгол: “Хавар цагийн шуурга хэцүү, хойт эхийн нударга хэцүү”

Япон: “Хойт эх үү, эсвэл ширүүн салхи уу”. Манай орны хувьд жилийн дөрвөн улиралтай бөгөөд эрс тэс уур амьсгалтай. Цаг уурын энэ эрс тэс байдал нь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчин монголчуудын хувьд ихээхэн учир

²⁵Ж. Баянсан “Эхээ үзэх монгол сэтгэлгээний онцлог”. //МУИС, МСС-ийн ЭШБ. 15-р боть. 4-р дэвтэр. УБ.,1999 х.23-28

холбогдолтой зүйл. Тэр тусмаа өвлийн зуд, зуны ган, хаврын хар шуурга нь малчин ардын амьдралд их халгаатай. Япон улс арал дээр тогтсон, далайгаар хүрээлэгдсэн орон учир байнга л далайн хар салхи шуурга тэдний сэтгэлийг зовоож мөн айлгаж байдаг. Энэ хахир хатуу ширүүн салхи шуургыг хойт эхтэй зүйрлэсэн нь өөрийн эхийг орлох хүн энэ дэлхийд байхгүй гэдгийг тодорхой харуулжээ.

Түүнчлэн эцэг эх, байгаль дэлхийгээ хайрладаг үзэл нь

Монгол: “Өндөр тэнгэр эцэг, өргөн дэлхий ээж”

Япон: “Эцэг тэнгэр, эх газар” адил туссан байна. Тэнгэр бол этүгэн, удган, онгон, бөртэ гэх тотем ухагдхууны нэг юм. “Монголчууд тэнгэр нь эр бэлгийг төлөөлүүлсэн тотемийн сүг сүнсний үзэл онгонд уусаж, мянга түмэн овоо хайрханы сүсэглэл нэгэнт дээд тэнгэрт хийдэм сэтгэцээр хурайнгуулагдсан”²⁶ гэж үздэг. Монгол, япончууд ийнхүү эцэг эхээ, арга билгийн үүднээс тэнгэр, газар гэж үзсэн нь ихээхэн сонирхолтой байна.

Япон үндэстэн нь хүнийг хүндлэхийн тухайд маш нарийн дэг соёлтой бөгөөд хөгшинхүнийг өөрийн эцэг эх мэт хүндэлдэг. Энэ нь тэднийг бага балчир наснаас нь хүнболгон төлөвшүүлэхдээ хүндлэл, ёс зүйн асуудлыг байнга сургадагтай ч холбоотой. Монгол хүн ч мөн ялгаагүй өтгөс өвгөд, эцэг эхээ хүндлэх арвин ёс суртахуунтай. “Ахмадыг хүндэтгэн халамжлах ёс нь Чингис хааны дээд удмын Бодончар мэргэний өгүүлснээс үзвэл маш эртний уламжлалтай ажээ”²⁷. Учир мэдэх өвгөд хөгшдийгмөнхрүүлж чадахгүй ч тэднийг урт удаан наслуулж, тэднээс суралцаж, асран сувилж, хайрлан хүндэтгэхийг эрхэм болгодог байж.

Монгол: “Ахаа алд хүндэл, дүүгээ дэлэм хүндэл”

Япон: “Хөгшин хүнийг эцэг мэт, залуу хүнийг дүү мэт хүндэл”

Монгол: “Өтлөхөд үр хэрэгтэй, өлсөхөд хоол хэрэгтэй”

Япон: “Өтлөхийн цагт үр хүүхдээ дага”. Залуу цагт эцэг эхийн сургамжаар

хүн болох ч өтлөхийн цагт өөрсдөө үр хүүхдээрээсруулах нь хүмүүний амьдрал билээ.

Тэрчлэн эцэг эхийн эрхэм үүрэг нь үр хүүхдээ зөв хүн болгон төлөвшүүлэх явдал бөгөөд иймийн тул хүүхдийн өөрийн хийсэн буруу зүйлийн хариулцлагыг өөрт хариуцуулж, буруугаа хүлээх чадварсуулган багаас нь зөв, бурууг ялгаж салгаж сургах нь чухал.

Монгол: “Нохойгоо өмөөрсөн хүн таарахгүй,

Хүүхдээ өмөөрсөн хүн хүнтэй таарахгүй”

Япон: “Хүүхдийн хэрүүлд эцэг эх оролцох”. Хүүхдийг багаас нь биеийг даалгахгүй, хайрлаж байна гээд хэт эрхлүүлэх нь эргээд эцэг эхэд зовлон болно гэдгийг эцэг эхчүүдэд анхааруулан сургамжилсан санаа байна.

Монгол, япон хэлний зүйр цэцэн үгийг харьцуулан үзэхэд утга агуулга ойролцоо ч илэрхийлж буй зүйрлэл, юм үзэгдлээрээ ялгаатай зүйр үгс ажиглагдлаа.

Жишээлбэл: *Монгол: “Сайн эцгийн нэрийг гурав худалдаж иднэ”*

Япон: “Эцэг эхийн цацраг долоон туяа” хэмээх хоёр зүйр үг нь сайн эцэг эхийн сайнд үр хүүхэд жаргана” гэсэн санааг илэрхийлэх бөгөөд чухамхүү хоёр орны тооны бэлгэдлийн зөрүүтэй сэтгэхүйнээс хамаарч зүйрлэл нь буюу харьцуулсан тоо нь өөр байна. Нүүдэлчин монгол түмэн гурав хэмээх тоог ертөнц хэмээн үзэж, аливаа зүйлийн учир холбогдлыг гурвын тоогоор тайлбарлах нь их. Монголчуудын гурвын тоог

²⁶Т. Өлзий “Эртний монголчуудын сэтгэхүйн хэв шинж, онцлог”. УБ.,2006

²⁷Х.Чагдаа “Монгол гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэл”. УБ.,2004. 59 дэх тал

эрхэмлэх үзэл нь монголчуудын сэтгэлгээтэй холбоотой агаад эцэг, эх, үр гурвын холбоо өнгөрсөн, одоо, ирээдүйн гурван цагийн хэлхээс болж нэг нь нөгөөгийнхөө үргэлжлэл болох, салгаж үл болох гэсэн утга бий. Мөн “гурав бол хамгийн анхны олныг төлөөлсөн сондгой тоо, аргын арга тоо учраас ямагт үл тэгширч цаашид өсч олширч байхын чанд утгыг агуулдаг”²⁸ билээ. Харин монголчууд бидний хувьд “үхэл мөхөл, уруудаж доройтохыг бэлгэддэг”²⁹ долоогийн тоог япончууд долоогийн тоог сайн гэж үздэг бөгөөд орчин үеийн залуус “Lucky 7” буюу азын долоо гэж долоогийн тоогоор аз бэлгэдэх нь их болжээ. Мөн долоо дахин цацрах гэдэг нь солонгын долоон өнгөтэй холбоотой болов уу.

Хүүхдийг нялх балчир цагаас ухаан, ухамсар суулган, зөв хүн болгон төлөвшүүлэх нь эцэг эхийн хэрхэн зааж сурган, хүмүүжүүлснээс шалтгаалдаг. Монгол, япончуудын үр хүүхдээ хүмүүжүүлэх сэтгэлгээний онцлогт үр хүүхдээ хайрлаж байна гээд хэт эрхлүүлэх, өөрийн биеийг нь даалгаж сургахгүй байх, бусдаас илүү үзэж зөв бурууг нь шүүн тунгаахгүй байх нь буруу зүйл болохыг анхааруулан сургамжилсан байна.

Монгол: “Буруу өсгөсөн хүүхэд, бухын хүзүүнээс хатуу”

Япон: “Эцэг эхийн чихэртэй цай хор болох”

Монгол: “Өөрийн үр дэлхий, хүний үр мэлхий”

Япон: “Эцэг эхийн нүд ялгавартай”, “Эцэг эхийн хайрын нүд”

Монгол: “Ачийг бачаар”, “Бурханаа бургасаар гуядах”

Япон: “Эцэг эхийн нүдийг үнсээр будах”. Япон зүйр цэцэн үгэнд эцэг эх үр хүүхдийнхээ буруу хийсэн үйлдлийг зөв бурууг үл шүүн, тэдгээр буруу үйлдэл нь харагдахгүй, бодит зүйлийг ялгаж чадахгүй байхыг нүд сохрох, нүд алагчлан харах зэргээр “нүд”-ээр тодотгосон байна.

Монгол: “Эх сайтын охин ухаалаг, Эцэг сайтын хүү сэцэн”

Япон: “Мэлхийний зулзага мэлхий”, “Эцэг эхтэйгээ адил мэлхийний хүүхэд” гэх зүйр үг нь эцэг эх нь ямар байна үр хүүхэд нь тийм байна, ажилтай хүний хүүхэд ажилтай байх ёстой гэсэн санааг илэрхийлнэ. Тариа будаа тарин аж төрдөг япончуудын хувьд мэлхий нь онцгой ач тустай амьтан аж. Мэлхий тариан талбайн элдэв хортон шавжийг идэж устгаж тариан талбайг хортон шавьжаас хамгаалдаг учир ажилч, хичээнгүй гэсэн сайн үнэлэмжтэй байна. Харин монголчуудын хувьд мэлхий нь сайн үнэлэмжгүй бөгөөд мэлхийг царай муутай, муу гэж үзэх нь бий.

Монгол: “Элээ шонхрыг төрүүлэх”, “Эгэл хүнээс энгүй хүн ч төрдөг”,
“Таван лангийн гүүнээс тавин лангийн унага”

Япон: “Хулсны хүү эцэг эхээсээ илүү”. Хулс нь маш хурдан ургадаг бөгөөд нэг шөнийн дотор дунджаар 10 сантиметр өсдөг гэнэ. Хулсны хүүхэд гэдэг нь хулс шиг хурдан өсөж дэвших гэсэн утгатай ба энэ нь эцэг эхээсээ илүү гэсэн санааг гаргажээ. Мөн үүнийг өөр нэг япон зүйр үгэнд “Элээ шонхрыг төрүүлэх” гэж хэлсэн байх ба эдгээр зүйр үгс Эдогийн үед³⁰ үүссэн байна.

Мөн монгол эх хүний “Үхтэл үр харам”, “Хүн үрийнхээ төлөө үхдэг, хонь сүүлнийхээ төлөө үхдэг”, “Эх хүн үрээ харж байхдаа гол нь тасардаггүй” гэсэн

²⁸С.Дулам “Монгол бэлгэдэл зүй I Тооны бэлгэдэл зүй”. УБ., 2009. 79-р тал

²⁹С.Дулам “Монгол бэлгэдэл зүй I Тооны бэлгэдэл зүй”. УБ., 2009. 127-р тал

³⁰Эдогийн үе /1603-1867 он/

хэллэгүүд японы “*Үр хүүхдийнхээ төлөө гурван нүүдэл хийсэн ээж*”³¹ гэсэн зүйр үгтэй илэрхийлэл өөр ч утга нь дүйж байна. Эх үрийн холбоо нь хамгийн нандин зүйл бөгөөд эх хүн үр хүүхдийнхээ сайн сайхны төлөө юуг ч хийж чаддаг. Үр хүүхдийнхээ төлөө гурван нүүдэл хийсэн гэх энэ зүйр үг Күнзийн сургаалаас үүдэлтэй. Японд Күнзийн сургаал Эдогийн үед нилээн орж ирсэн ба зарим зүйр үг нь японы уугуул зүйр үг мэт хэвшин тогтож хэрэглэгдсээр иржээ.

Түүнчлэн японы “*Үр хүүхдээ хамгийн сайн мэдэх нь эцэг*” гэсэн зүйр үг бий. Энэ эцэг хүн хүүхдийнхээ сайн муу бүх зан чанарыг сайн мэддэг гэсэн утгатай ба Хятадын Чин гүрний Энх-Амгалан хааны үед хэрэглэгдэж байсан “*臣を知ること君主に如くなし*”。*Боолоо хамгийн сайн мэдэх нь хаан эзэн*” гэсэн зүйр үгээс үүссэн байна. Энэ мэт японы зүйр үгэнд хятадын соёлын нөлөө их туссан байна.

Япон хэлэнд “*Эцэг эхээсээ түрүүлж нас барвал ачлалгүй хэрэг*” гэх зүйр цэцэн үг байх ба энэ нь үр хүүхэд нь эцэг эхээсээ түрүүлээд хорвоогийн мөнх бусыг үзэх нь эцэг эхийн хувьд туйлийн хэцүү зовлон юм. Үхэх төрөх нь ертөнцийн нэгэн үзэгдэл хэдий ч үр хүүхдийнхээ үхэхийг харна гэдэг эцэг эхийн төсөөлж байгаагүй зүйл “гэдгийн цаана төрүүлсний эцэст эцэг эхээ ачлах нь хүн болж төрсний зайлшгүй шалтгаалцмал үр, “үүрэг” тохоолго гэх санаа агуулдагийг, хайхрахгүй өнгөрөх аргагүй мэт. Сүүлийн хэллэгийг шууд утгаар нь үзвэл, эцэг эхээсээ түрүүлж үрэгдсэн хүүхдээ “ачлалгүйн” жишиг болгосон нь энэрэлгүй, хахир хатуу ёс мэт төсөөлөгдөж болзошгүй ч, эцэг эхийг ачлалыг хариулах нь амь наснаас эрхэм дээд зүйл гэдгийг чухалсан санаа бололтой.”³²

Аав ээжийнхээ ачийг өөрөө үр хүүхэдтэй болсон цагтаа ухаарах ба тэднийхээ ачийг амьдад нь баярлуулж чадаагүй бол өөрийнхөө үр хүүхдийг сайн, зөв хүмүүжүүлж тэрхүү ачийг нь нөхөн хариулаарай гэсэн санаа ихээхэн тусчээ.

“*Өөрөө үр хүүхэдтэй болсон цагт эцэг эхийн ачийг мэдрэнэ*”,

“*Эцэг эхийнхээ ачийг үр хүүхдээрээ хариулна*”

Түүнчлэн усны ачийг эцэг эхийн ач мэт, мөн түүнээс ч илүү гэж үзэх нь бий. Япончууд үр хүүхэддээ усны ач тус, усыг чандмань эрдэнэ мэт хайрлан хамгаалахыг үргэлж сургаж иржээ. Хүмүүс бид усгүйгээр амьдарч чадахгүй бөгөөд бидний амьдралд ус маш чухал зүйл билээ.

“*Эцэг хийн ач, усны ачийг хариулж чадахгүй*”,

“*Эцэг эхийн ачийг хариулж чадах ч, усны ачийг хариулж эс чадах*”

Эрт цагт япончууд 姥捨て буюу хөгшин эцэг эхээ ууланд тавьдаг тухай ардын аман зохиол, үлгэр туульд их гардаг. Япон улсын Нагано мужид эрт дээр үед үбасүтэ [обасүтэ] гэх нэгэн уул байжээ. Үүнтэй холбоотой нэг үлгэрт “Нэгэн залуу хүү эхнэртэй болжээ. Хөгшин настай ээжтэйгээ амьдрах нь түүний эхнэрт таалагдаагүй учир өндөр уулын орой дээр хаяхаар явжээ. Хөгшин ээжийгээ хаячихаад явж байхдаа бүтэн сарыг хараад ихэд харамсан эхийгээ буцаад аваад ирсэн” гэж гардаг. Энэхүү зан үйл бодит амьдрал дээр байсан үгүй нь эргэлзээтэй байдаг. Гэхдээ зарим нэг аймагт ийм заншил

³¹ Мэнзи/Күнзийн сургаалыг дагагч хятадын сэтгэгч МЭӨ372-289/-ийн ээж анх оршуулгын газрын ойролцоо амьдардаг байсан бөгөөд хүү нь оршуулах ёслолыг дуурайн тоглож байгааг хараад хотын төв руу нүүжээ. Гэсэн ч хүү нь энэ удаа худалдаачдыг дуурайн тогложбайгааг харан мөн л тусгүй хэмээн бодож сургуулийн хажууд нүүж очсоноор хүүхдийнхээ ирээдүйг зааж өгсөн гэх хууч домогоос үүсэн гарсан зүйр үг.

³² Ц.Онон “Монгол Япон хүний сэтгэлгээний нийтлэг ба өвөрмөц онцлогийг хэлний илэрхийллээр шинжлэх нь- Гэр бүлийн хамаат үг хэллэгийн жишээгээр”. Хэл бичгийн ухааны докторын зэрэг горилсон зохиол. УБ., 2013

байжээ. Гэр орон нь ядуу, эцэг эх нь хөгширсөн учир хөгшин эцэг эх нь үр хүүхэддээ дараа болж амьдрахгүйн тулд ийнхүү уулруу гардаг байж. Зарим үед өөрөө уулруу зугтан алга болох ч, ихэнхдээ явж чадамгүй хөгшин учир үр хүүхэд нь аваачиж тавьдаг байж. Энэ зан үйлийн тухай зүйр үгэнд ч бас туссан байна.

家貧^{いままず}しくして親老^{おや}いれば縁^{えん}を扱^{えら}ばずして仕^{つかう}う。(Ядуу болоод эцэг эх чинь хөгширвөл холбоо хамаарлаа бодолгүй өөрийнхөөрөө шийд.)

Мөн эцэг эхтэй холбоотой зүйр үгэнд мөнгөний талаар бас орсон байна.

“Эцэг эхийн нуруу ч гэсэн үнэгүйгээр маажихгүй”,

“Эцэг эх, үр хүүхэд мөнгөн дээр танихгүй хүн”,

“Ганц зоосыг ч тэр эцэг эх шигээ сана”. Япончуудын хувьд мөнгөний үнэ цэнийн үнэлэмж нилээн өндөр байдаг. Энэ нь мөнгийг хөлс хүчээ шавхан, хөдөлмөрлөн байж олдог зүйл болохоор мөнгөний үнэ цэнийг үр хүүхэддээ сайтар ойлгуулахыг хүсчээ. Тэрчлэн “Эцэг эх зовж, үр хүүхэд жаргаж, ач зээ гуйлгачин болох” гэсэн зүйр үгнээс ч мөнгөний үнэ цэнийг мэдрээгүй, өөрийн хөлс хүчээр мөнгө олж үзээгүй хүн бусдын мөнгийг үрэн таран хийхэд амархан гэдгийг хэлжээ.

“地震^{じしん} 雷^{かみなり} 火事^{かじ} 親父^{おやじ} Газар хөдлөлт, цахилгаан, гал түймэр, эцэг” энэ зүйрлэл нь дэлхий дээр дөрвөн төрлийн аюулт гамшиг бий гэсэн санааг гаргасан байна. Эцгийн эрхт ёсын үед эцэг хүний сүр хүч их байсан ба ааваасаа айж эмээн, сүрддэг байсан учир ийнхүү хамгийн их айж эмээдэг зүйлтэй зүйрлэсэн бололтой.

Монгол, япон хэлний эцэг эхийн тухайт зүйр үгс утга агуулга, зүйрлэлийн хувьд адил төстэй зүйл олон байгаа нь хүн төрөлхтөн орчлон ертөнцийн зүй тогтлыг нэгэн загвараар ойлгож хүлээж авдагтай холбоотой. Мөн ерөөс хүн хийгээд мал амьтаны үр төлөө гэх цэвэр ариун сэтгэл, үр хүүхэд нь эцэг эхээ хүндэтгэх хайрлах сэтгэл нь угаас заяамал зүйл билээ. Хоёр хэлэнд аль алинд нь эцэг эхийг үзэх үзэл нь эцэг эхийн үрээ гэх сэтгэл, үр хүүхдийн эцэг эхээ гэх сэтгэлтэй холбогдох агаад үр хүүхдээ зөв хүн болгон хүмүүжүүлэхэд эцэг эхийн нөлөө асар их, мөн үр хүүхэд эцэг эхийн ачийг ямагт санан, тэднийгээ асран тэтгэж, ачийг нь хариулаарай гэсэн сургамжит хийгээд ёс зүйн хүмүүжил олгох зүйр үг их байлаа.

НОМЗҮЙ

1. Г. Аким “Монгол зүйр цэцэн үгийн тайлбар толь”. УБ., 2001
2. Ж. Бат-Ирээдүй “Зүйр цэцэн үгийг зүйлээр хуваасан толь”. УБ., 2005
3. Ж. Баянсан “Хэл, соёл, үндэстний сэтгэлгээ”. УБ., 2002
4. С. Дулам “Монгол бэлгэдэл зүй I Тооны бэлгэдэл зүй”. УБ., 2009
5. Д. Заяабаатар, Ш. Чоймаа “Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж”. УБ., 1999
6. Т. Өлзий “Эртний монголчуудын сэтгэхүйн хэв шинж, онцлог”. УБ., 2006
7. Х. Чагдаа “Монгол гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэл”. УБ., 2004
8. Д. Дэлгэрсүрэн “Монгол, Япон хүний эцэг эхээ үзэх сэтгэлгээний онцлогийг харьцуулан судлах нь”. Магистрын зэрэг горилсон дипломын ажил. УБ., 2012
9. Ц. Онон “Монгол Япон хүний сэтгэлгээний нийтлэг ба өвөрмөц онцлогийг хэлний илэрхийллээр шинжлэх нь- Гэр бүлийн хамаат үг хэллэгийн жишээгээр”. Хэл бичгийн ухааны докторын зэрэг горилсон зохиол. УБ., 2013
10. 鈴木棠三編“続故事ことわざ辞典”東京堂出., 1958

11. 三省堂編修所“故事ことわざ・慣用句辞典”1999
12. 中川善之助著“夫婦・親子”民法講話、日本評論新社刊、1959

SUMMARY

There are many previous studies about the concept for the parents of Japanese and Mongolian children. However, side-by-side comparisons studies show that on the national characters of the two people, discussed in the terms of cultural studies and sociolinguistics sayings about the parents in particular, have not been touched too much.

Therefore, how the culture behind it and the features of the concept of the parents of the two countries, clarify the point at which the expression forms of the proverb about the parents of Japanese and Mongolian, similarities and differences, are expressed in the proverb of the comparisons. I thought if I've understand, and would like to consider.